

1987 оны 9-р сард Улаанбаатар хотноо хуралдсан ОУМЭ-ийн V их хурлаар Монгол судлалын цар хүрээг тэлсэн онол, эрдэм шинжилгээний чухал ач холбогдолттой олон тооны илтгэл тавигдсан билээ. Дотоод гадаадын эрдэмтдийн тэдгээр 300 шахам илтгэл ОУМЭ-ийн байнгын хорооны шугамаар тусгай ботиуд болон хэвлэгдэх боловч уншигчдын хүсэлтээр зарим илтгэлийг дээж болгон тус сэтгүүлийн энэ оны хоёрдугаарт нээсэн «Монгол судлалын индэр» дэд буланд нийтлэн толилуулж байна.

## МОНГОЛ СУДЛАЛЫН ИНДЭР

## МОНГОЛЧУУДЫН ӨЛГИЙ НУТАГ, ГАРАЛ ҮҮСЛИЙГ ГЕНЕ- ТИКИЙН СУДАЛГААГААР МӨШГӨСӨН НЬ

Ж. БАТСУУРЬ

Биологийн ухааны доктор


Антропологийн ухаан үүссэн цагаас хүн төрөлхтний гурван том расын нэг нь «Монгол» хэмээх нэрээр монгол төрхтнүүд гэж нэрлэгдэх болсон авч монголчуудын гарал үүсэл, Азийн бусад монгол төрхтнүүдтэй тэдний холбогдох удмын хэлхээ холбоо, ялгааг генетикийн үүднээс хөндсөн дорвитой судалгаа эдүгээ хүртэл байхгүй юм.

Археологийн судалгаа, цаг уур газар зүйн тогтоцын онцлогт тулгуурлан Азийн монгол төрхтнүүдийн өвөг дээдсийн өлгий нутаг бол Төв Ази байх үндэстэй гэсэн таамаглал ёсоор эх газрын монгол төрхтнүүдийн газар зүйн өлгий нутагт Монгол хамаарагдах бөгөөд чухамхүү түүний хүрээнд эртний чулуун зэвсгийн үед өнөөгийн Азийн монгол төрхтнүүдийн өвөг дээдсийн төрх үүсч бүрэлдэн тогтсон байна. Сүүлийн жилүүдэд явуулсан палеантропологийн судалгаагаар хүрэл зэвсгийн үеэс эхлэн Төв Монгол нутагт иргэншиж байсан дөрвөлжин булшны соёлын эздийн антропологийн хэв шинж Монголын түүхийн дараахь үеүдэд өв удмын холбоотой хөгжиж ирсэн болох нь илэрсэн юм<sup>1</sup>. Орчин цагийн монголчуудын Төв Азийн антропологийн хэв шинж хүннүгийн үе (М. Э. Ө III—I) зуун буюу манай эрины эхэнд үндсэндээ бүрэлдэн тогтсон байна<sup>2</sup>.

Энэхүү өгүүлэлд бусад судлаачид болон 18 аймаг, Улаанбаатар хотын хүн амд бидний хийсэн судалгааг нэгтгэн шинжилж монголчуудын өлгий нутаг, гарал үүслийн тухай асуудлыг генетикийн үүднээс хөндөж мөшгөсөн дүнгээс<sup>3</sup> толилуулах зорилт тавьсан юм. Антропологийн хэв шинжээр монголчууд, Умард Азийн монгол төрхт угсаатнуудыг бүхэлд нь эх газрын монгол төрхтнүүд, Хятад, Япон, Солонгосын хойгийн монгол төрхт угсаатнуудыг номхон далай хавийн монгол төрхтнүүд гэж үндсэн хоёр салбар монгол төрхтнүүд болгон ангилдаг<sup>4</sup>

Умард Азийн болон Номхон далай хавийн хоёр салбар монгол төрхтнүүдээс монголчуудын ялгагдах генетик онцлог болон гарал үүслийн хувьд тэдэнтэй хэрхэн холбогдох тухай асуудлыг генетикийн судалгаанд тулгуурлан анх удаа хөндөх оролдлог хийсэн юм<sup>5</sup>. Харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд монголчуудын генийн сан монгол төрхтнүүдийн генийн санг бүхэлд нь төлөөлж чадахуйц тийм нийтлэг генетик онцлогтой болох нь илэрсэн явдал монгол төрхтнүүдийн өвөрмөц генетик онцлогууд монголчуудын генийн санд түгээмэл байдалтай хадгалагдан үлдсэний нотолгоо бололтой.<sup>6</sup>

Дэлхийн хүн амтай харьцуулахад монголчуудад ихээхэн өндөр тархалттай генүүд Монголын төв хэсэгт хамгийн өндөр давтамжтай бөөгнөрөн хадгалагдаж үлдсэн болох нь илэрсэн бөгөөд чухамхүү энэ генийн бөөгнөрлийн хүрээ, түүний газар зүйн төвийг генетикийн аргаар тооцон гаргасныг харуулсан болно. (Зураг № 1)



1-р зураг. Монголчуудын генийн сан бүрэлдэн тогтсон өлгий нутгийн газарзүйн байршил

● Аймгийн төв

▨ Монголчуудын генийн сан бүрэлдэн тогтсон өлгий нутгийн хил хязгаар

▲ Монголчуудын генийн сангийн газарзүйн төв

◎ Улаанбаатар—БНМАУ-ын нийслэл


Таримал ургамал, малын үүлдэр угсааны гарал үүслийн газар зүйн төвийг тогтоохдоо боловсруулсан Н. И. Вавиловын<sup>7</sup> онолын үүднээс авч үзэхэд газар зүйн энэ хэсгийг монголчуудын генийн сан бүрэлдэн тогтсон өлгий нутаг хэмээн үзэж болохыг генетикийн судалгааны тооцоолол харуулж байгаа юм<sup>8</sup>.

Гэвч генетикийн аргаар тогтоосон энэ өлгий нутаг нэг талаас монголчууд тэдгээрийн өвөг дээдсээс хэдэн арван мянган жилийн турш эрхлэн хөгжүүлж ирсэн мал аж ахуйн экологийн нөхцөл, Төв Ази ялангуяа Монгол нутагт удаа дараа үүсч хөгжиж байсан эртний ул суудын улс төр түүх, соёлын төв, газар зүйн байршилтай нөгөө талаас хэрхэн уялдаж байгааг авч үзье.

Генетикийн аргаар илрүүлсэн монголчуудын өлгий нутаг газарзүйн хувьд Хангай нуруу түүнээс Хэнтий нуруу хүртэлх нутгийг эзлэхдээ хойд талаараа тайгын бүс, урд талаараа говиор эмжээрлэгдсэн явдал тохиолдлын чанартай бус болов уу.

Газарзүйн хувьд аваад үзэхэд энэ нутаг нь Төв Азийн усны хагалбар цөм төдийгүй нөгөө талаас бэлчээрийн мал аж ахуйн хамгийн эрчимтэй хөгжил, нягтшил бүхий район юм. Ийнхүү монголчуудын генийн сан бүрэлдэн тогтсон өлгий нутаг мал аж ахуйн хөгжлийн экологийн гол район хоорондоо яв цав давхцаж байгаа нь огт санамсаргүй зүйл бишээ.











Нөгөө талаас монголчуудын генетик өлгий нутгийн төв хүннүгээс эхлэн Төв Азид төр улсаа байгуулан оршин тогтнож байсан эртний улсуудын улс төрийн төвүүдтэй давхцаж байгаа (зураг 2) нь бас л санамсаргүй зүйл гэх үндэсгүй юм<sup>9</sup>.



2-р зураг Монголчуудын генетик өлгий нутаг Монгол нутагт үүсч бүрэлдэн тогтож байсан улсуудын газар нутаг хоорондын хамаарал



Монголчуудын генетик өлгий нутгийн тархалтын хүрээ.

	Монголчуудын генийн сангийн өлгий нутгийн газарзүйн төв
	Хүннү, сяньби, түрэг, XIII зууны монгол улсын улс төрийн төв
	Хүннү гүрний хил (МЭӨ I зуун)
	Сяньби улсын хил (III—IV зуун)
	Жужан улсын хил (IV—VI зуун)
	Түрэг улсын хил (VI—VIII зуун)
	Уйгур улсын хил (VIII—IX зуун)
	Хятан улсын хил (X—XII зуун)
	Нэгдсэн монгол улсын хил (XIII—XIV зуун)
	Хятадын их цагаан хэрэм

Түүхийн гүнээс уламжлагдан ирсэн нүүдлийн мал аж ахуйн амьдралын хэвшлийг экологийн үүднээс авч үзэхэд монголчуудын гарал үүслийн түүх, тэдгээрийн экологи салшгүй холбоотой болохыг генетикийн судалгааны дүн ийнхүү харуулж байна. Экологийн аясаар нуудлийн мал аж ахуй эрхлэн амьдархад уур амьсгал газарзүйн онцлог, бэлчээр, хөрс, ус, ургамал нь жигдхэн хосолсон аятай таатай район бол монголчуудын генетик өлгий, түүхэн төвөөсөөр хаана ч Төв Азид байхгүй болохоор эртний нүүдэлчдийн улс удаа дараа энд үүсч, эсвэл энэ төв нутаг руу тэмүүлсээр байсан нь зүй тогтлын хэрэг байжээ.

Түүхчдийн таамаглалаар монгол угсаатан үүсч<sup>10</sup> бүрэлдэн тогтсон<sup>11</sup> өлгий нутаг бол гурван голын сав газар<sup>12</sup> боловч генетикийн судалгаа Төв Азийн эртний нүүдэлчдийн түүх-улс төр, экологийн төв нутагт монголчууд бүрэлдэн тогтсон болохыг гэрчилж байна.

Түүх-генетикийн судалгааны дүн хоорондоо ийнхүү зөрөөтэй байгаа нь бидний нээж илрүүлсэн өлгий нутагт монголчуудын генийн сан цаг хугацааны хувьд XIII зууны эхэнд монгол угсаатан бүрэлдэн тогтохоос өмнө үүсч түүхийн гүнээс өнөөгийн монголчуудад өвлөгдөн ирснийг гэрчилж буй хэрэг бололтой<sup>13</sup>.

Иймээс өнөөгийн монголчуудын генийн сан тэдний өвөг дээдсийн өлгий нутагт цаг хугацааны хувьд түүхийн чухам ямар үед үүссэн байж болох вэ? гэдэг асуулт зүй ёсоор тавигдаж байна.

Түүхийн баримт мэдээ, археологи палеантропологи<sup>14</sup> судалгаагаар хүрлийн сүүлч, төмрийн түрүү үед Алтай, Хангайн нурууны заагаар европ монгол төрхтнүүдийн хооронд холицолдол явагдаж эхэлсэн нь тогтоогдсон билээ. Үүнтэй холбон европ төрхтнүүдээс гаралтай байж болох зарим генийн газарзүйн тархалтанд<sup>15</sup> хийсэн шинжилгээнээс үзэ-


хэд монголчуудын генийн сан<sup>16</sup> тэдгээрийн өлгий нутагт наад зах нь төмрийн түрүү үеэс үүссэн гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монгол, түрэг хоёр угсааны чухам алинд нь хамаарах тухай маргаантай асуудал хэрхэн яаж шийдэгдэхээс үл хамааруулан үзэхэд төмрийн түрүү үед чухамхүү хүннү<sup>17</sup> нар л Төв Азид анх төр улсаа байгуулан гарч ирсэн билээ.

Монголчуудын генийн сангийн голомт хүннү улсын нутаг дэвсгэр түүний улс төрийн төвөгтэй явцав давхцаж байгаа явдал (Зураг. 2) өнөөгийн Монголчуудын генийн сангийн голомт ямар ч байсан Төв Азид хамгийн түрүүн төр улсаа байгуулан гарч ирсэн хүннү нараас өвлөн ирсэн болохыг тодорхой харуулж байна. (Зураг 2)

Түүхчдийн хувьд маргаантай угсаа хэлээрээ биш юм гэхэд ямар ч байсан генетикийн хувьд умард хүннүчүүд, бүр цаашилбал тэдгээрээр шууд уламжлагдан түүхийн гүнээс Төв Ази, ялангуяа Монгол нутагт иргэншиж байсан өвөг дээдсээс орчин үеийн монголчууд гаралтай байж болох нь удмын холбоосуудад<sup>18</sup> илэрч байна.


Генийн газарзүйн тархалтанд хийсэн шинжилгээ монголчуудын генийн сангийн өлгий голомт угсаатны өнөөгийн тархац нутагт хэрхэн ямар үе шаттай<sup>19</sup> тархсан болохыг нөхөн сэргээж босгох (Зураг 3) боломжинд хүргэсэн юм.



3-р зураг. Монголчуудын генийн сан үүссэн өлгий төвөөсөө хүрээгээ тэлсэн үндсэн үе шатууд

- ◎ Улаанбаатар—БНМАУ-ын нийслэл
- Аймгийн төв
- ▲ Монголчуудын генийн сангийн өлгий нутгийн газар зүйн төв

Монголчуудын генийн сан хүннүчүүдээс өвлөгдсөн хэмээх баталгаанаас үзвэл генийн сангийн өлгий угсаатны өнөөгийн нутагт тархах процесс таван үе шаттайгаар 2000 жилийн турш явагджээ гэж үзэх бүрэн үндэстэй юм. Хэрэв эдгээр таван үе шатны нэг нь дунджаар 400 жил үргэлжилсэн юм гэж үзвэл эхнээсээ гурав дахь буюу зураг дээр хэвтэй тасархай зураасаар тэмдэглэсэн шат 1200 оны үед буй болсон буюу монгол угсаатан бүрэлдэн тогтсон түүхэн үетэй давхцаж байна. Өөрөөр хэлбэл монголчуудын генийн сан үүслийн өлгий нутгийн хүрээ аажим



**4-р зураг.** Монгол төрхтнүүдийн гарал үүслийн газарзүйн төв



Умард Азийн монгол төрхтнүүдийн гарал үүслийн Төв Азийн өлгий нутаг, түүний цаашид салбарлан хөгжихөд үүссэн үндсэн голомтуудын хил хязгаар



Умард Азийн болон Номхон далай хавийн монгол төрхтнүүдийн газарзүйн тархалтын генетикийн аргаар тогтоосон хил

тэлэгдсээр түүхэн баримт мэдээгээр монгол угсаатан бүрэлдэн тогтсон гурван голын сав нутгийг XIII зууны эхэнд хамарчээ гэж үзэх нь зүйтэй. Монголчуудын өлгий нутаг бол Төв Монгол болох тухай генетикийн судалгааны баталгаа, гурван голын савд үүссэн байж болох тухай түүхчдийн, таамаглал хоорондын уялдаа ийнхүү тайлагдаж байна.

Монгол төрхтнүүдийг нийтэд нь хамруулсан генийн газарзүй тархалтын зураглалаар умард, Төв болон зүүн азийн хүрээнд генетикийн сангийн гурван том төв (зураг 4) байгаа нь илэрсэн<sup>20</sup> юм.

Тархац нутгийн хэмжээгэр хамгийн томд Сибирь-Төв Азийн төв орж байна. Бусад хоёр төв нь тархац нутгийн хувьд жижиг урал, арктикийн

монгол төрхтнүүдтэй холбогдох бөгөөд Сибирь Төв Азийн төвөөс хожуу салбарлан үүссэн болох нь тодорхой байна.

Генийн сангийн энэхүү генетик цөмүүд нь таримал, ургамал гэрийн тэжээмэл амьтдын гарал үүслийн тухай Н. И. Вавиловын онолын<sup>21</sup> үүднээс авч үзэхэд монгол төрхтнүүдийн гарал үүсэл, генетик хуваагдлын газарзүйн төвүүд мөн болох<sup>22</sup> нь шинжилгээгээр батлагдсан юм.

Номхон далай хавийн монгол төрхтнүүдийн генийн сан өөрийн газарзүйн төвгүй Төв Ази, Зүүн Азиас харилцан миграци\* холилцолдол явагдсаны дүнд үүссэн болох нь илэрсэн явдал антропологийн, түүх этнографийн судалгаанд тулгуурлан умард хятадуудын антропологийн хэв шинж бүрэлдсэн тухай Н. Н. Чебоксаровын<sup>23</sup> үзлийг нэхэн баталж буй хэрэг.


Олон мянган жилийн турш явагдсан ийм миграцийн үр дүнд түүхийн гүнээс ан агнуур, мал аж ахуй эрхлэн ирсэн Умард Азийн монгол төрхтнүүд, газар тариалан эрхэлсэн амьдралын хэвшилтэй номхон далай хавийн монгол төрхтнүүдийн хооронд түүх, археологи, антропологийн судалгаагаар тогтоогдсон хил зааг (зураг дээр босоо шугамаар харуулсан болно) эдгээр ард түмний генийн санд хадгалагдаж үлдсэн нь (зураг 4) генетикийн судалгаагаар<sup>24</sup> илэрлээ.

Алтай, Саяны орчмоор Монгол төрхтний зэрэгцээ неолитын үеэс нутаглаж байсан европ төрхтнүүдийн ул мөр Төв Ази—Сибирийн генийн газарзүйн голомтод байхгүй байгаагаас үзэхэд энэ голомт төв неолитын өмнөх мезолит аль эсвэл дээд палеолитын үед хамрагдах үндэстэй байна. Нөгөө талаас «Монгол төрхтнүүдийн онцлог генүүд цугларсан генийн газарзүйн голомт түүхийн ямар ч үед хамрагдлаа гэсэн Байгаль нуураар голчлон баруун зүүн гэсэн хоёр хэсэгт хуваагджээ. Үүнээс үзэхэд Төв Ази-Сибирийн генийн сангийн голомтууд Монгол төрхтнүүдийн генийн сан бүрэлдэн тогтож эхлэх үед бус түүнээс хожуу чухамхүү Дээд палеолит<sup>25</sup> буюу түүний эхэнд<sup>26</sup> хамрагдах нь илүү магадлалтай юм.


Монголчуудын генийн сангийн голомт хүннүгээс өмнөх үед чухам ямар өв суурин дээр үүсээ вэ? Монголчуудын генийн сан монгол төрхтнүүдийн нийт генийн сангаас чухам ямар онцлог ялгаатай байна вэ? зэрэг асуултанд хариулахын тулд Монголын болон Азийн генийн газар зүйн тархалтын ерөнхий зургуудыг (1, 4) хооронд нь давхцуулан шинжлэхэд хүрэлцээтэй болно. (Зураг 5)

Хүннүгүүдээс уламжлагдан ирсэн монголчуудын генийн сангийн голомт Байгаль нуураар голчлон түүний баруун зүүн жигүүрээр дээд палеолитын эхэн үед салбарлан тархаж байсан монгол төрхтнүүдийн генийн сангийн голомтуудын суурийг хооронд нь холбон үүссэн болох нь харагдаж байна<sup>27</sup>.

\* — Миграци-нүүдэллэх, шилжих



5-р зураг. Монголчууд, монгол төрхтнүүдийн гарал үүслийн өлгий нутгуудын хоорондын давхцал




Монголчуудын генийн сангийн үүслийн өлгий нутаг



Умард Азийн монгол төрхтнүүдийн гарал үүслийн Төв Азийн өлгий нутаг, түүний цаашид салбарлан хөгжихөд үүссэн үндсэн голомтуудын хил хязгаар



Монгол төрхтнүүдийн генийн сангийн гарал үүслийн Төв Азийн өлгий голомт дээр монголчуудын генийн сан үүссэн онцлог



Умард Азийн болон Номхон далай хавийн монгол төрхтнүүдийн газарзүйн тархалтын генетикийн аргаар тогтоосон хил

Ийнхүү өнөөгийн монголчуудын Төв Азийн антропологийн хэв шинжинд монгол төрхтний генийн сангийн гадаад нэгдмэл илрэл шингэжээ хэмээн үзэх бүрэн үндэстэй юм. Чухамхүү энэ утгаараа антропологийн ангилалаар хүн төрөлхтний расуудын нэгийг «Монгол» хэмээх нэрээр зөнч байдлаар боловч зөв овголсны учир шалтгааны нууц Монголчуудын генийн сан, Монгол төрхтний генийн сангийн голомтыг өвлөн үүссэнд оршино.

<sup>1</sup> **Д. Тумэн** Вопросы этногенеза монголов в свете данных палеантропологии.

Автореферат диссертации кандидата исторических наук. М., 1985. 20 с.

<sup>2</sup> **Д. Тумэн** Вопросы этногенеза монголов в свете данных палеантропологии.

Автореферат диссертации кандидата исторических наук. М., 1985. 20 с.

<sup>3</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук М., 1986.

<sup>4</sup> **Алексеев В. П.** География человеческих рас М. Мысль, 1974 а, 351 с.

<sup>5</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии, Диссертация на соискание ученой степени доктора биологических наук. М., 1986.

<sup>6</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народа населения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук. М., 1986.

<sup>7</sup> **Вавилов Н И.** Географические закономерности в распределений генов культурных растений. -В кн: «Классика советской генетики». Л. 6 Наука, 1968, стр 51 — 57.

<sup>8</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук. М., 1986,

<sup>8</sup> **Рычков Ю. Г., Батсуурь Ж.** Монголы МНР и монголоидное население Азии в свете геногеографии. Вопросы антропологии, вып. 78, 1987.

<sup>9</sup> История Монгольской Народной Республики. М. Наука, 1983, 661 с.

<sup>10</sup> **Гонгор Д.** Халх товчоон. УБ. 1970, т. 1

<sup>11</sup> **Пэрлээ Х.** Собственно монгольские племена в период киданьской империи (907—1125) УБ., 1961

<sup>12</sup> **Ишжамц Н.** Монгол угсаатан үүсэн бүрэлдсэн тухай. Студия этнографии, 1965, т. 11, стр. 21-28

<sup>13</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986.

<sup>14</sup> **Грум-Гржимайло Г. Е.** Западная Монголия и Урянхайский край Л., 1926, т. п. 628 с.

<sup>14</sup> **Гумилев Л. Н.** Хунну. М., 1960

<sup>14</sup> **Дебец Г. Ф.** Еще раз с белокурой расе в Центральной Азии «Советская Азия», 1931, No 5-6.

<sup>14</sup> **Мамонова Н. Н.** Палеодемография улангомского могильника, В. кн.: Археология и этнография Монголии. Новосибирск, 1978, стр. 123— 135

<sup>14</sup> **Тумэн Д.** Вопросы этногенеза монголов в свете данных палеантропологии.

Автореферат диссертации кандидата исторических наук. М, 1985. 20 с.

- <sup>15</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народа населения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986
- <sup>16</sup> **Рычков Ю. Г., Батсуурь Ж.** Монголы МНР и монголоидное население Азии в свете геногеографии. Вопросы антропологии, вып. 78, 1987.
- <sup>17</sup> История Монгольской Народной Республики. М.: Наука, 1983, 66/с
- <sup>18</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986
- <sup>19</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986
- <sup>20</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986
- <sup>21</sup> **Вавилов Н. И.** Географические закономерности в распределений генов культурных растений. -В кн: «Классики советской генетики», Л. 6 Наука, 1968, стр. 51-57
- <sup>22</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986
- <sup>23</sup> **Чебоксаров Н. Н.** К вопросу о происхождении северных китайцев. Советская этнография, 1974, № 1
- <sup>24</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1986
- <sup>25</sup> **Батсуурь Ж.** Наследственный полиморфизм и геногеография народонаселения Монголии. Диссертация на соискание ученой степени доктора биологических наук, М., 1
- <sup>26</sup> **Рычков Ю. Г., Батсуурь Ж.** Монголы МНР и монголоидное население Азии в свете геногеографии. Вопросы антропологии, вып. 78, 1987,
- <sup>27</sup> **Рычков Ю. Г., Батсуурь Ж.** Монголы МНР и монголоидное население Азии в свете геногеографии. Вопросы антропологии, вып. 78, 1987,